



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 30 өдөр Дугаар А/136.

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 32,134,974.00 (гучин хоёр сая нэг зуун гучин дөрвөн мянга есөн зуун далан дөрөв) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг актгалж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль (Р.Энхбат)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 20066 ширхэг нийт 32,134,974.00 (гучин хоёр сая нэг зуун гучин дөрвөн мянга есөн зуун далан дөрөв) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий ном, сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 11 дүгээр сургууль (Р.Энхбат)-д үрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2025 оны 0... дугаар сарын 10. -ны
өдрийн А/Н дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль

| № | Хөрөнгийн нэр төрөл | Ашигласан жил | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | нийт дүн | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэх өртөг | Данснаас хасах шалтгаан | ӨХБЗөвлөлийн дүгнэлт | ҮХХХК-ын хурлыг шийдвэр |
|---------------------------|---------------------|---------------|------------|--------------|---------------|-----------------------|----------------------|---------------------------------|----------------------|-------------------------|
| 1 | Номын фонд | 9 | 20066 | 4,030,065.00 | 32,134,974.00 | - | 32,134,974.00 | Эрүүл ахуйн шаардлага хангахгүй | актлах | актлах |
| Нийт дүн | | | | | | | 32,134,974.00 | | | |
| Үүнээс. Худалдах хөрөнгө | | | | | | | | | | |
| Устгах хөрөнгө | | | | | | | 32,134,974.00 | | | |
| Татан төвлөрүүлэх хөрөнгө | | | | | | | | | | |
| Худалдсанаас олох орлого | | | | | | | | | | |
| НӨХГ-т төвлөрүүлэх /30%/ | | | | | | | | | | |